

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод эдийн засгийн өсөлт нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн байх зорилгыг дэвшүүлэн “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, дундаж давхаргыг бүрдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д эдийн засгийн өсөлтийг 6 хувьд хадгалж, нэг хүнд ногдох үндэсний орлогыг 2 дахин нэмэгдүүлж, ажиллах хүчний оролцооны түвшнийг 65 хувьд хүргэнэ гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1-д заасан “Татварын шинэчлэл”-ийн хүрээнд бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын орчныг олон улсын стандартад нийцүүлэх зэрэг зорилтуудыг тус тус тусгасан.

Татварын хууль тогтоомжуудад шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулах зорилгоор Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар хамтран улс орон даяар давхардсан тоогоор 11,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 176 мянга орчим саналыг хүлээн авсан. Хэлэлцүүлгийн явцад аж ахуйн нэгжүүдээс татвар ногдуулах орлогын босгыг нэмэгдүүлэх, шатлалыг өөрчлөх, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн хөнгөлөлт, чөлөөлөлтийг нэмэгдүүлэх, холбогдох зардлуудыг хасагдах зардалд тооцох, тайлан гаргах хугацааг уян хатан болгох, хүний нөөцийг чадавхжуулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, бизнес эрхлэхэд татварын орчныг илүү хялбар, энгийн, ойлгомжтой болгох зэрэг саналуудыг нийтлэг байдлаар ирүүлсэн.

Түүнчлэн Ойрх Дорнодод үүссэн геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн газрын тосны үнийн тогтворгүй байдлаас үүдэн инфляцын түвшин нэмэгдэж, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өсөх нөхцөл бүрдээд байна. Энэ нь макро эдийн засгийн болон бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдал, иргэдийн бодит орлого, худалдан авах чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Иймд гадаад орчноос үүдэлтэй эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах, инфляцын гэнэтийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, аж ахуйн нэгжүүдийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих шаардлага тулгараад байна.

Дээрх бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх, орлогын татварын орчныг олон улсын нийтлэг жишгээр боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийг хөдөлмөр эрхэлж, баялаг бүтээж буй иргэдэд чиглүүлэх зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төсөлд дараах үндсэн чиглэлийг баримталж, холбогдох зохицуулалтыг тусгасан. Үүнд:

Нэг. Татварын хөнгөлөлтийн бодлогыг оновчтой, хүртээмжтэй болгох замаар иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулна.

Сүүлийн жилүүдэд геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилж, тодорхой бус байдал нэмэгдэх, эдийн засгуудын өсөлт удаашрах зэрэг эрсдэлүүд үргэлжилсээр байна. Олон улсад иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор тодорхой түвшнээс бага орлого олсон тохиолдолд татварын хөнгөлөлтийг буцаан олгох хэлбэрийн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг нийтлэг жишигтэй.

Иймд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд хэрэгжиж буй хөнгөлөлтийн бодлогыг орлогын хэмжээнээс үл хамааран бүх иргэдэд эдлүүлэх, үйл ажиллагааны орлоготой иргэдийг хамруулах, хөнгөлөлтийн хэмжээг нэмэгдүүлэх, мөн сургалтын төлбөртэй тэнцэх хэмжээний орлогод үзүүлдэг албан татварын хөнгөлөлтийг босготой болгох зэрэг зохицуулалтуудыг тусгаж, хөнгөлөлтийн бодлогыг оновчтой, хүртээмжтэй болгох замаар нийт иргэдийн дундаж татварын ачааллыг бууруулна.

Хоёр. Хялбаршуулсан горимоор тайлагнах татварын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгоно.

Хялбаршуулсан горимоор тайлагнан 1 хувиар татвар төлөх босгыг 1 тэрбум төгрөг болгох зохицуулалтыг тусгах замаар бүх нийтээрээ шударга төлөх татварын орчныг бүрдүүлнэ.

Гурав. Иргэдийн орон сууцжуулалтыг татварын бодлогоор дэмжинэ.

Хувь хүн тодорхой хугацаанд өмчилсөн өөрийн орон сууцаа худалдан борлуулахад үл хөдлөх хөрөнгө борлуулсны татвараас чөлөөлнө.

Дөрөв. Татвар төлөгчдийн тайлан тушаах, татвар төлөх хугацааг хойшлуулна.

Иргэдийн тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах хүрээнд татвар төлөх болон тайлагнах хугацааг сунган уян хатан болгоно.

Ийнхүү хуулийн төсөл батлагдсанаар нийт иргэдийн татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг нэмэгдүүлэн урт хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн тогтвортой өсөлтийг дэмжих зэрэг эерэг үр дагавартай байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулна.

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод эдийн засгийн өсөлт нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн байх эрхэм зорилгыг дэвшүүлэн “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, дундаж давхаргыг бүрдүүлнэ”, “Нийгмийн бүх салбарт тэгш бус байдлыг багасгаж, дундаж орлоготой иргэдийн тоог нэмэгдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг дунджаар 6 хувьд хадгалж, нэг хүнд ногдох үндэсний орлогыг 2 дахин нэмэгдүүлж, ажиллах хүчний оролцооны түвшнийг 65 хувьд хүргэнэ гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр заасан бөгөөд энэ хүрээнд бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах, татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгох зорилтуудыг тус тус тусгасан.

Татварын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2019 онд Улсын Их Хурлаас баталж, 2020 оноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэхүү шинэчлэл нь бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого олж буй хувь хүн болон хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдний татвар төлөхтэй холбогдох зардлыг бууруулах, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах үндсэн зорилготой байсан.

Хуулийн шинэчлэлээс хойших хугацаанд геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилж, худалдааны бодлогоос үүдэлтэй тодорхой бус байдал нэмэгдэх, голлох эдийн засгуудын өсөлт удаашрах зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвт бий болоод байна.

Түүнчлэн Ойрх Дорнодод үүссэн геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн газрын тосны үнийн тогтворгүй байдлаас үүдэн инфляцын түвшин нэмэгдэж, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өсөх нөхцөл бүрдээд байна. Энэ нь макро эдийн засгийн болон бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдал, иргэдийн бодит орлого, худалдан авах чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Иймд гадаад орчноос үүдэлтэй эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах, инфляцын гэнэтийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, аж ахуйн нэгжүүдийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих шаардлага тулгараад байна.

Олон улсын практикт хувь хүний орлогын албан татварын бодлогоор бага, дунд орлоготой иргэн, өрхийн татварын дараах бодит орлогыг нэмэгдүүлэх зорилго бүхий арга хэмжээг өргөнөөр авч хэрэгжүүлдэг. Тухайлбал сүүлийн жилүүдэд Бүгд

Найрамдах Солонгос Улс, Люксембургийн Их Гүнт Улс, Данийн Хаант Улс зэрэг орнууд иргэдийн татварын хөнгөлөлтийг буцаан олгох хэлбэрээр эдлүүлж, иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулах бодлогыг баримталж байна.

Ийнхүү хурдацтай өөрчлөгдөж буй дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, дотоодын нийгэм эдийн засгийн сорилтуудыг харгалзан өнөөгийн хувь хүний орлогын албан татварыг олон улсын нийтлэг жишгээр боловсронгуй болгох, орлогын тэгш бус байдлыг бууруулах зорилттой уялдуулан эдийн засгийн өсөлтийг хөдөлмөр эрхэлж, баялаг бүтээж буй иргэдэд чиглүүлэх шаардлага бий болж байна.

Татварын хууль тогтоомжуудад шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах зорилгоор Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар хамтран улс орон даяар давхардсан тоогоор 11,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 176 мянга орчим саналыг хүлээн авсан. Хэлэлцүүлгийн явцад нийтлэг байдлаар ирүүлсэн иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг боловсронгуй болгох, татвар төлөх, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах зэрэг саналуудыг хуулийн төсөлд тусгах нь зүйтэй байна.

Дээрх бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх, орлогын татварын орчныг олон улсын нийтлэг жишгээр боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийг хөдөлмөр эрхэлж, баялаг бүтээж буй иргэдэд чиглүүлэх зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд үзэл баримтлалд тусгасан үндсэн чиглэлийг баримталж, дараах холбогдох зохицуулалтыг тусгасан. Үүнд:

Нэг. Татварын хөнгөлөлтийн бодлогыг оновчтой, хүртээмжтэй болгох замаар иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйлд татварын хөнгөлөлтийг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох зохицуулалтыг тусгалаа.

Тодруулбал одоогийн хуулиар зөвхөн жилийн 36 сая төгрөг хүртэлх цалингийн орлоготой иргэдэд үзүүлдэг 240 мянга хүртэлх төгрөгийн шаталсан хөнгөлөлтийг орлогын хэмжээнээс үл хамааран бүх иргэдэд эдлүүлэх, үйл ажиллагааны орлоготой иргэдийг хамруулах, хөнгөлөлтийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг болно.

Ингэснээр хөдөлмөр эрхэлж буй бүх иргэн сарын 500 мянган төгрөг хүртэлх орлогодоо 100 хувь орлогын татвараас хөнгөлүүлж, тухайн жилийн татварын тайлангаа тооцож баталгаажуулсны үндсэнд буцаан авснаар нийт иргэдийн дундаж татварын ачаалал буурах юм.

Хоёр. Хялбаршуулсан горимоор тайлагнах татварын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгоно.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд үйл ажиллагааны орлогын хялбаршуулсан горим буюу 1 хувиар татвар төлөх зохицуулалтад 1 тэрбум төгрөгийн босго тогтоон бүх нийтээрээ шударга төлөх татварын орчныг бүрдүүлэх зохицуулалтыг тусгалаа.

Гурав. Иргэдийн орон сууцжуулалтыг татварын бодлогоор дэмжинэ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд хувь хүн тодорхой хугацаанд өмчилсөн өөрийн орон сууцаа худалдан борлуулахад үл хөдлөх хөрөнгө борлуулсны татвараас чөлөөлөх зохицуулалтыг тусгалаа.

Дөрөв. Татвар төлөгчдийн тайлан тушаах, татвар төлөх хугацааг хойшлуулна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд иргэдийн тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах хүрээнд татвар төлөх болон тайлагнах хугацааг сунган уян хатан болгох зохицуулалтыг тусгалаа.

Ийнхүү хуулийн төсөл батлагдсанаар нийт иргэдийн татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг нэмэгдүүлэн урт хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн тогтвортой өсөлтийг дэмжих зэрэг эерэг үр дагавартай байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулна.

---oOo---